



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/80

Аргалын уул

Газар эзэмшүүлэх тухай

Монгол улсын “Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний, удирдлагын тухай хууль-ийн 29.2, Монгол улсын “Газрын тухай хууль”-ийн 27 дугаар зүйл, 30 дугаар зүйлийн 30,1 дэхь заалт, 33 дугаар зүйлийн 33.1.1 дэхь заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 11 дүгээр тогтоолоор баталсан “Сумын газар зохион байгуулалтын 2019 оны төлөвлөгөөг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Хөшөөт багийн нутаг Галзуу хар сууринд хөдөө аж ахуйн цогцолбор байгууламжийн зориулалтаар 4 га газрыг 5674522 регистрийн дугаартай, 9011392066 улсын бүртгэлийн дугаартай Хөдөө аж ахуйн бирж төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанид 15-н жилийн хугацаатай эзэмшүүлсүгэй.

2.Эзэмшил газраа зориулалтын дагуу байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүйгээр эзэмшиж, газрын төлбөрийг хуулийн хугацаанд төлж байхыг Хөдөө аж ахуйн бирж ТӨХХК гүйцэтгэх захирал /Х.Баатар /-т үүрэг болгосугай.

3.Хуулийн дагуу холбогдох материалыг бүрдүүлж гэрээ хийж гэрчилгээ олгохыг газрын даамал /О.Эрдэнэчулуун /-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.БАТЖАРГАЛ

